



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БҮРД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/56

Бүрд сум

Ажил хүлээлцэх комисс  
томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Хоёр дугаар багийн "Иргэний танхим"-н барилгын ажлыг хүлээж авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга	Д.Алтанцэцэг (Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга	Д.Балжинням (Нягтлан бодогч)
Гишүүдэд	Г.Солонго (ХЖДҮ хариуцсан мэргэжилтэн) Ж.Энхмаа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн) Э.Жагварал (2 дугаар багийн Засаг дарга)

2.Ажлын тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээж авахыг Ажлын хэсэг (Д.Алтанцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.МӨНХБАЯР



Өвөрхангай аймгийн Бүрд сумын 2-р багийн "Иргэний танхим"-н  
барилгын ажлыг хүлээж авах тухай хуралдааны тэмдэглэл.

2023.07.06

Бүрд сум

Сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 12 ний өдрийн а/56 тоот захирамжаар томилогдсон "Иргэний танхим"-н барилга хүлээж авах комиссын хуралдаан нь дарга Д.Алтанцэцэг, гишүүд Д.Балжинням, Ж.Энхмаа, Э.Жагварал, Г.Солонго нарын бүрэлдэхүүнтэй 100%-ийн ирцтэй 2023 оны 07 дугаар сарын 6-ны өдөр 16 цаг 30 минутад Засаг даргын орлогчийн өрөөнд эхэллээ.

Хэлэлцэх асуудал: Барилгын ажлын гүйцэтгэлийг хүлээлцэх тухай.

Д.Алтанцэцэг: Барилгын ажлын гүйцэтгэлийн хувьд хийсэн ажил зураг төсвийн дагуу сайн хийгдсэн байна. Харин нэмэлтээр цонхонд хамгаалалт төмөр, ус зайлуулагч, гадна хайс хийлгэх саналтай л байна.

Д.Балжинням : Надад дотор талын хана цагаан өнгөтэй биш арай өөр өнгөөр хийсэн бол зүгээр санагдаж байна. Энэ барилгыг барьж эхэлж байхад нь суурь хундаам цутгаж байхад нь явцын хяналтаар очиж барилгын материалтай танилцсан чанартай сайн материал татан авсан байсан барилгын ажил бол зураг төсвийн дагуу сайн хийгдсэн байна мөн Алтанцэцэг даргын адил нэмэлт ажил хийлгэх саналтай байна.

Ө.Өлзий-Очир : Нэмэлтээр хийх цонхны хамгаалалт, ус зайлуулагчийг хийж болж байна. Би анхнаасаа Засаг даргыг хайс хийлгэх нэмэлт гэрээ байгуулна гэхэд нь хүлээн зөвшөөрөөгүй. Төсвийн тооцоогоор зардал өндөртэй байсан, нэгэнт хайс хийвэл чанартай гоё юм л хиймээр байгаа.

Ж.Энхмаа : Цонхны хамгаалалтаа хэзээ хийх юм.

Ө.Өлзий-Очир : Нэмэлт ажил болох цонхны хамгаалалт болон цонхны доод хаялга төмөр зэргийг 8 дугаар сарын 5-ны дотор хийж гүйцэтгэнэ.

Ж.Энхмаа: Одоо хүлээж авлаа гэхэд цонх хагарсан тохиолдолд хамгаалалт хийгээгүй хугацаанд хэн хариуцах вэ.

Ө.Өлзий-Очир: Барилга хүлээлцсэн тохиолдолд би хариуцахгүй.

Д.Балжинням : Тэгвэл хамгаалалт хийсний дараа хүлээлцмээр байна.

Э.Жагварал: Хийх ёстой гэрээт ажлаа зураг төсөвт зааснаар нь бүрэн хийж дууссан учир хүлээж авах саналтай байна.

Г.Солонго: Жагваралтай санал нэг байна. Хийвэл зохих ажлаа сайн хийсэн. Хайс бол угаасаа хийх боломжгүй гэж байгаа.

Ж.Энхмаа: Хайсыг багийн Засаг дарга иргэдээсээ зохицуулах юм уу.





Э.Жагварал : Хайсыг иргэддээ санал тавья.Иргэд яаж хүлээж авахыг мэдэхгүй.  
Цонхны хамгаалалт хийхээс өмнө цонх хагарвал би хариуцна.

Ж.Энхмаа: Эрсдэлийг нь хүлээх эзэнтэй багийн Засаг дарга хариуцах болохоор барилгын ажлыг хүлээж авахаас татгалзах зүйлгүй.

Э.Жагварал: Наадмын амралт дуусгаад цонхны хамгаалалтаа хийчих.  
Шийдвэрлэсэн нь: Ажил хүлээлцэх комиссын гишүүдийн олонхийн саналаар "Иргэний танхим"-н барилгын ажлыг хүлээж авахаар боллоо.

Хуралдаан мөн өдрийн 18 цаг 10 минутад дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн гишүүн : *D. Baljinnyam* Д.Балжинням  
Барилгын ажил хүлээж авсан комиссын дарга : *D. Altantsyag* Д.Алтанцэцэг  
Гишүүд: *E. Javgaral* Э.Жагварал  
*G. Solongo* Г.Солонго  
*J. Enkhmaa* Ж.Энхмаа  
Хүлээлгэн өгсөн: Өлгий ээж ХХК-ны  
Гүйцэтгэх захирал *O. Ochiir* Ө.Өлзий-Очир

